

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий Сансар эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/137/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Аудитор: Р.Баярмаа Утас: 99265539 Цахим хаяг: bayarmaar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал.....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Төлбөрийн акт	14
Төлбөрийн акт тогтоогдоогүй.	14
5.2 Албан шаардлага.....	14
5.3 Зөвлөмж	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА Х.МАНЧУК ТАНАА

2024.02.23 № 184
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Өлгий Сансар" эмнэлгийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ний өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Өлгий Сансар" эмнэлгийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ний өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 212 дугаар тогтоол, Засаг даргын 2023 оны А/677 дугаар захирамжаар "Өлгий Сансар" эмнэлгийг Нэгдсэн эмнэлгийн бүтцэд шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

"Өлгий Сансар" эмнэлгийн өр төлбөрийг 2024 оны орон нутгийн төсөвт тусган батлуулахаар шийдвэрлэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402763

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ЖАЙГУЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	89348307.70	0.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	28221.76	0.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	28221.76	0.00
31110	Төгрөг	28221.76	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	89320085.94	0.00
351	Түүхий эд материал	5668623.27	0.00
35130	Эм боох материал	5668623.27	0.00
354	Хангамжийн материал	83651462.67	0.00
35410	Бичиг хэргийн материал	4075114.00	0.00
35420	Аж ахуйн материал	72809354.90	0.00
35430	Сэлбэг хэрэгсэл	163000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	796529.95	0.00
35460	Хүнсний материал	5718180.20	0.00
35470	Бусад хангамжийн материал	89283.62	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	402003073.10	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	402003073.10	0.00
392	Биет хөрөнгө	303399073.10	0.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	375190350.62	0.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	0.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	125317248.19	0.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	6862000.00	0.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-6862000.00	0.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	111664140.00	0.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-65624523.51	0.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	20679001.00	0.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13192646.82	0.00
393	Биет бус хөрөнгө	98604000.00	0.00
39301	Програм хангамж	550000.00	0.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	0.00
39303	Бусад биет бус хөрөнгө	98604000.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	491351380.80	0.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	129444905.29	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	129444905.29	0.00
413	Өглөг	129444905.29	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	67034252.04	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1677117.00	0.00
4136	Бусад өглөг	60733536.25	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	60733536.25	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	361906475.51	0.00
51	Засгийн газрын хувь оролцоо	361906475.51	0.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	179512371.00	0.00
51101	Өмч: - төрийн	179512371.00	0.00
512	Хуримтлагдсан үр дүн	-	0.00
		125352149.85	0.00

Өлгий Сансар эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51210	Өмнөх үеийн үр дүн	-	439974109.79
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	439974109.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	307746254.36	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	491351380.80	0.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	498,215,090.00	241,516,900.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	7,579,665.00	9,711,600.00
110	Орлогын албан татвар	7,579,665.00	9,711,600.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	7,579,665.00	9,711,600.00
110002	Үйл ажиллагааны орлого	7,579,665.00	9,711,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	490,635,425.00	231,805,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	490,635,425.00	231,805,300.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	490,635,425.00	231,805,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	692,274,555.42	241,545,121.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	692,274,555.42	241,545,121.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	668,488,655.42	240,845,121.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,325,321.00	163,334,472.95
210101	Үндсэн цалин	382,325,321.00	163,334,472.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,392,475.00	17,500,000.00
210201	Тэтгэврийн даатгал	48,392,475.00	17,500,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,239,617.04	7,205,000.00
210301	Гэрэл, цахилгаан	6,953,217.00	3,400,000.00
210302	Түлш, халаалт	14,737,200.04	3,805,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,549,200.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	29,821,662.00	880,500.00
210401	Бичиг хэрэг	1,872,000.00	
210402	Тээвэр, шатахуун	5,034,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	880,000.00	600,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,709,750.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	19,325,912.00	280,500.00
2105	Нормативт зардал	120,089,731.57	32,630,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	102,298,486.57	29,500,000.00
210502	Хоол, хүнс	17,791,245.00	3,130,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,928,303.48	4,504,901.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,928,303.48	4,504,901.81
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,691,545.33	14,790,247.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,790,247.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,691,545.33	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,785,900.00	700,000.00

Өлгий Сансар эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	23,785,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,785,900.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	700,000.00
213504	Хөрөнгийн	-	700,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(194,059,465.42)	(28,221.76)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	439,945,888.03
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	402,674,073.10
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	-	37,271,814.93
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(439,945,888.03)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(194,059,465.42)	(439,974,109.79)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	553215090.00	241516900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7579665.00	9711600.00
120	Нийтлэг татварын бус орлого	7579665.00	9711600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7579665.00	9711600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7579665.00	9711600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	545635425.00	231805300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	545635425.00	231805300.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	545635425.00	231805300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	546882414.54	240845121.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	546882414.54	240845121.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	523096514.54	240845121.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	341385553.96	163334472.95
210101	Үндсэн цалин	341385553.96	163334472.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37994200.00	17500000.00
210201	Тэтгэврийн даатгал	37994200.00	17500000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18775600.00	7205000.00
210301	Гэрэл, цахилгаан	6870000.00	3400000.00
210302	Түлш, халаалт	11205600.00	3805000.00
210303	Цэвэр, бохир ус	700000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	20606750.00	880500.00
210401	Бичиг хэрэг	2333000.00	
210402	Тээвэр, шатахуун	3900000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	880000.00	600000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2709750.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10784000.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		280500.00
2105	Нормативт зардал	85518671.10	32630000.00

Өлгий Сансар эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59540671.10	29500000.00
210502	Хоол, хүнс	25978000.00	3130000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18815739.48	4504901.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17928303.48	4504901.81
210807	Газрын төлбөр	887436.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	14790247.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		14790247.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23785900.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23785900.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23785900.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6332675.46	671778.24
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6399000.00	700000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6399000.00	700000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6399000.00	700000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6399000.00	700000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-6399000.00	-700000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-66324.54	-28221.76
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	94546.30	28221.76
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28221.76	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	179,512,371.00	307,746,254.57	68,707,315.57		555,965,941.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	179,512,371.00	307,746,254.57	68,707,315.57	0.00	555,965,941.14
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-194,059,465.42		-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	179,512,371.00	307,746,254.57	-125,352,149.85	0.00	361,906,475.72
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	179,512,371.00	307,746,254.57	-125,352,149.85	0.00	361,906,475.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	179,512,371.00	307,746,254.57	565,326,259.64		78,067,634.07
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	439,974,109.79	0.00	439,974,109.79

Өлгий Сансар эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-439,974,109.79		439,974,109.79
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Өлгий Сансар” эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дотор, сэргээн засах чиглэлээр хэвтүүлэн эмчлэх, ахмад настай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй, Эрүүл мэндийн даатгалын сантай гэрээ байгуулан гүйцэтгэлээр санхүүждэг байгууллага юм.

Тайлант онд “Үйлчлүүлэгчдэд ээлтэй, нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг чанартай үзүүлэх” гэсэн зорилго дэвшүүлж ажилласан байна.

Тус эмнэлэг нь аймгийн Засаг даргын харьяа Санхүү, төрийн сангийн хэлтэст санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг орон нутгийн өмчийн байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Өлгий Сансар” эмнэлэг нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Тус эмнэлэг нь тогтмол төсөвгүй, гүйцэтгэлээр санхүүждэг ба санхүүгийн хүндрэлээс үүдэж 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс үйл ажиллагаагаа зогсоосон байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар 09-ний өдрийн 136 дугаар тогтоолоор “Өлгий Сансар” эмнэлгийг орон нутгийн өмчит эмнэлэг болгон өөрчлөн байгуулсан байна.

Тус тогтоолын 3 дахь заалтад тус эмнэлгийг улсын эмнэлэг болгох ажлыг эхний хагас жилд багтаан холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын орлогчид үүрэг болгосон байна.

Өлгий Сансар эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ИТХ-ын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийг 170 дугаар тогтоолоор “Өлгий Сансар” эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулан дүрмийг баталсан боловч санхүүгийн хүндрэлийн улмаас дүрэмд заасан зорилго, зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа оновчтой зохион байгуулж чадаагүй байна.

“Өлгий Сансар” эмнэлгийн зүгээс болон УИХ-ын гишүүд, аймгийн удирдлагуудаас үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон талаар Эрүүл мэндийн яамд асуудал тавьж ирсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 1а/4177 албан бичгээр эмнэлгийн нийт ажилтнуудыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн бүтцэд авч ажиллуулах чиглэлийг ирүүлсэн байна.

Үүний дагуу аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/582 дугаар захирамжаар байгуулагдсан ажлыг хэсэг эмнэлгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, төсөв санхүүгийн баримтад хяналт хийж, эмнэлгийн хүний нөөц, санхүү, орон нутгийн өмчийн чиглэлээр дүгнэлт гаргасан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 212 дугаар тогтоолоор “Өлгий Сансар эмнэлгийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн бүтцэд шилжүүлэн ажиллуулахтай холбогдуулан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн харьяалах нутаг дэвсгэрийнхээ эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, оновчтой байршуулах, материаллаг бааз, хүний болон санхүүгийн нөөцийг зохистой хуваарилахыг аймгийн Засаг дарга болон Нэгдсэн эмнэлгийн даргад үүрэг болгосон байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/677 дугаар захирамжаар “Өлгий Сансар” эмнэлгийг Нэгдсэн эмнэлгийн бүтцэд шилжүүлсэн байна.

Дээрх шийдвэрийн дагуу Өлгий Сансар эмнэлгийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 624,110,8 мянган төгрөгийн хөрөнгийг Нэгдсэн эмнэлэгт балансаас балансад шилжүүлсэн байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Өлгий Сансар” эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Өлгий Сансар эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

“Өлгий Сансар” эмнэлгийн даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг баталж үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Өлгий Сансар” эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон байна.

“Өлгий Сансар” эмнэлгийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөр гаргасан санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 87.6 сая төгрөгөөр буюу 17.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	28.22	00.0	-28.22
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	89,320.09	37,271.81	-52,048.28
Үндсэн хөрөнгө	402,003.07	366,508.73	-35,494.34
Нийт хөрөнгө	491,351.38	403,780.54	-87,570.84
Өр төлбөр	129,444.91	486,485.86	357,040.95
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	361,906.47	-82,705.31	-444,611.78
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	491,351.38	403,780.54	-87,570.84

Мөнгөн хөрөнгө, авлага данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 37.3 сая төгрөг болж оны эхнээс 52.0 сая төгрөгөөр буурсан байна. Эм боох материалын үлдэгдэл 2.1 сая, бичиг хэргийн материал 2.7 сая, аж ахуйн материал 32.4 сая төгрөг байна. Төсвийн хөрөнгөөр 60.9 сая төгрөгийн материал худалдан авсан байна.

Тайлант онд байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтэд үндэслэн даргын тушаалаар 28.3 сая төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 366.5 сая төгрөг болж 35.5 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 2.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Аймгийн ИТХ-ын тогтоолоор 1.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 486.5 сая төгрөг болж өмнөх оноос 357.0 сая төгрөгөөр өссөн байна. Тус эмнэлэг нь гүйцэтгэлээр санхүүждэгтэй холбоотой орлогоо бүрдүүлж чадаагүйтэй холбоотой ажилчидтай холбоотой 105.6 сая, бараа үйлчилгээний зардлын 1.7 сая, байгууллага болон хувь хүмүүст төлөх 249.9 сая төгрөг болж өссөн байна. Энэхүү өглөгт тус эмнэлгийн өндөр насны тэтгэвэрт гарч буй 11 албан хаагчид олгох 228.4 сая төгрөгийн тэтгэмжийн өглөг орсон байна.

Өлгий Сансар эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аймгийн ИТХ-ын 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 212 дугаар тогтоолоор тус эмнэлгийн 2023 оны 9 дүгээр сарын байдлаарх халаалт, цахилгаан, цалин, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, бохир усны төлбөр, эмийн нийт 250.9 сая төгрөгийн, тэтгэвэр тэтгэмжийн 188.0 сая төгрөгийн өрийг 2024 оны орон нутгийн төсөвт тусгаж батлуулахыг аймгийн Засаг даргад үүрэг болгосон байна.

Тус тогтоол дахь өрийн дүнд тэтгэвэрт гарах албан хаагчийн жагсаалтад тухайн үед нягтлан бодогчийн нэр ороогүй байсантай холбоотой тэтгэмжийн өглөг 24.97 сая, ХХОАТ-ын өглөг 22.6 сая төгрөгөөр санхүүгийн тайлан дахь өрийн үлдэгдэл болон тогтоол дахь өрийн дүнгээс зөрүүтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 444.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн -444.6 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

“Өлгий Сансар” эмнэлгийн 2023 оны хаалтын санхүүгийн байдлын тайлан дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	28.22		-28.22
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	37,271.81		-37,271.81
Үндсэн хөрөнгө	366,508.73		-366,508.73
Нийт хөрөнгө	403,780.54		-403,780.54
Өр төлбөр	486,485.86		-486,485.86
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-82,705.31		-82,705.31
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	403,780.54		-403,780.54

“Өлгий Сансар” эмнэлгийн 2023 оны хаалтын санхүүгийн тайлангаар Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 37.3 сая төгрөгийн бараа материал, 614.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө /хуримтлагдсан элэгдэл нь 247.7 сая төгрөг шилжүүлсэн байна.

Харин аймгийн ИТХ-ын 2023 оны 212 дугаар тогтоолд тус эмнэлгийн өр төлбөрийг 2024 оны төсөвт суулгаж барагдуулах чиглэлийн дагуу нийт 486.5 сая төгрөгийн өр төлбөр нь аймгийн Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайланд үлдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

“Өлгий Сансар” эмнэлэг нь Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүждэг байгууллага тул батлагдсан төсөвгүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

“Өлгий Сансар” эмнэлэг нь 2023 оны 1-10 дугаар сард Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр 231.8 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 9.7 сая

Өлгий Сансар эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

төгрөгийн орлого бүрдүүлж нийт 241.5 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Тус эмнэлэг нь төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд ороогүй байгууллага тул төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргадаггүй болно.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

“Өлгий Сансар” эмнэлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

“Өлгий Сансар” эмнэлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

“Өлгий Сансар” эмнэлэг нь 2023 онд 60.9 сая төгрөгийн материал, 2.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Өлгий Сансар” эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Баярмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

“Өлгий Сансар” эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг “Өлгий Сансар” эмнэлгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 692.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн 30 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар шилэн данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Өлгий Сансар” эмнэлгийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тус эмнэлгийн он дамжсан өр төлбөрийн барагдуулалтыг анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Алдаа зөрчил илрээгүй.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн														

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн												

Өлгий Сансар эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит